

“ГУРВАН ГОЛ”-ЫН ДУРСАМЖ

Б.Сэржав

Их хааны онгоныг хайх “Гурван гол” төслийн орчуулагчаар ажилласан минь жирийн судлаач миний амьдралд тохиолдсон ихээхэн аз завшаан байж, мартагдашгүй сайхан дурсамж үлдээжээ. Монгол, Японы Засгийн газар хоорондын “Соёлын хэлэлцээр”-ийн дагуу хоёр тал оюутан судлаач, багш нар, соёл урлагийнхан, ном хэвлэл, судалгааны материалын солилцоо явуулж, эрдэм шинжилгээний хамтарсан ажил эхэлж, 1980-аад он гэхэд цар хүрээ нь улам тэлж ирсэн. ШУА-д ажилладаг япон хэлтэй гэгдэх залуус тэр үед бүгд ээлж дараалан Япон улсад очиж мэргэжил дээшлүүлж ирсний эхний хэд нь Дорнодахины судлалын хүрээлэнгийн бид нар байсансан. Миний бие Оосакагийн Гадаад судлалын их сургуульд 2 жил суралцаад 1989 оны 4 дүгээр сард буцаж ирсэн маань манай улсад нийгэм солигдох уур амьсгал, “хувьсгалын тохироо” ид бүрэлдэж асан цаг үетэй таарсан.

1989 оны 5 дугаар сард Япон улсын Гадаад хэргийн сайд Үно Соосүкэ анх удаа манай улсад албан ёсны айлчлал хийсэн нь хоёр орны харилцааны хөгжилд томоохон түлхэц өгсөн. Айлчлалын дараагаас хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа бүх чиглэлээр эрчимтэй өрнөж эхлэхэд шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа манлайд нь байж, чухам л Гурван гол төслөөр хүчээ авсан гэхэд буруудахгүй байх. Харин миний хувьд бол судалгаа шинжилгээний олон салбарыг хамарч, хоёр талын сор болсон олон эрдэмтэн судлаачид оролцон Монгол орны түүхт газар шороон дээр 3 жилийн турш үргэлжлэн хэрэгжсэн тэр том төслийн монгол, япон 10-аад орчуулагч нарын нэг нь л байсан гэж өөрийгөө боддог. Төслийн эрдэм шинжилгээний ажлын үйл явц, учир холбогдол, цар хүрээ, үр дүн, ач холбогдлыг экспедицийн үе шат бүрт гаргасан эрдэм

шинжилгээний тайлан, хоёр талын эрдэмтдийн бүтээл туурвилд тодорхой тусгасан байдаг. Төслийн орчуулагч нар хурал зөвлөгөөн, хээрийн хайгуулын үеийн ажлаас гадна аж ахуйн болон өдөр тутмын ахуй амьдрал, хэвлэл мэдээлэл, сум орон нутгийнхантай холбоотой гээд бүхий л үйл явдалд хэл залгуулдаг байв. Хүрээлэнгийн ажлын өрөө, номын сан хавиас бараг хэтэрч үзээгүй жижигхэн ажилтан миний хувьд Монгол, Японы нэр цуутай эрдэмтэд судлаачдын хооронд орчуулга хийх ажлын ялдамд Монгол Улсынхаа өнө эртнээс нааших агуу түүхийг чихээрээ сонсож, найман зууны чанадын суут үйл хэргийн ул мөрийг хадгалан дэлхийн анхаарлыг соронзон мэт татсаар ирсэн дагшин газар нутаг, уул уснаа хөл тавьж, хараа бэлчээж явсан минь эх түүх, яндашгүй соёл, Монгол орноо танин мэдэхээс эхлээд судалгаа шинжилгээний ажлын арга барилыг ойлгож авах, монгол хүн байхын утга учраа мэдрэхэд ч хүртэл чухамдаа үгээр илэрхийлж дийлэхээргүй ач тусаа өгснийг хэзээ ч мартахын аргагүй.

Гурван голын экспедицид зөвхөн хээрийн судалгааны ажилд л гэхэд монгол, япон хоёр талаас тус бүр 50, 60 хүн явсан, Японы талаас хэвлэл мэдээллийнхэн, зохиолчид, нийгмийн зүтгэлтэн гээд ховор содон хүмүүс энэ экспедицийн шугамаар манай улсад зочилж байсан. Японы алдарт зохиолч, япончуудын шүтээн болсон агуу хүн Шива Рёотароо 1989 оны 8 дугаар сард ирсэн. ШУА-ийн Ерөнхийлөгч, академич Н.Содном гуай хүлээн авч уулзахад нь миний бие хэлмэрч хийж билээ. Мөн Гурван голын экспедицийн анхны танилцах аялалын багтай Хэнтий аймгийн нутгаар зочлоход нь ч судалгааны багийн орчуулгыг хийсэн. Шива Рёотароо зохиолчийг 1990 оны намар Оосака Гадаад судлалын их сургуулийн төгсөгчдийн уулзалтад оролцох үеэр нь тус их сургуульд ажиллаж байсан нэрт яруу найрагч, доктор Д.Отгонсүрэн багш түүнтэй уулзаж ярилцлага авснаа “Утга зохиол” сонинд 1991 онд нийтлүүлсэн. Монгол Улсад хоёронтоо зочилсон их хүмүүн тэрээр “...Онгоцноос буухдаа тал нутгийг харж, дэлхийн бөмбөрцөг дээр суугаа бүх хүн Монголын газар нутгийг хамгаалах ёстой. Ийм үнэт сайхан нутгийг хүн төрөлхтөн хойч үедээ хадгалж үлдээх ёстой. Монголын хээр тал бол хүн төрөлхтний эрдэнэ мөн гэж бодсон...” хэмээн хэлсэн байдаг. Монголын тухай зохиолууд нь, бас энэ ярилцлагад туссан олон утга санаа нь монгол хүн, Монголын тал нутгийн өнөө хийгээд ирээдүйн талаарх түүний халуун сэтгэлийг

илэрхийлэн үлдсэн гайхамшигт өв билээ. Шива Рёотароо зохиолчоос гадна нэрт зохиолч Кайко Такэши, Чин Шюншин нар ч бас манай улсад зочилсон. Японы Дорнодахины түүхийн архив Тооёо Бүнко-гийн захирал, алдарт археологич Эгами Намио, Япон дахь Монгол судлалын гол төлөөлөгчдийн нэг, Монголын түүх, Монголын Нууц Товчоо судлалын нэрт эрдэмтэн Мүраками Масацүгү, Олон улсын Монгол судлалын холбооны Ерөнхийлөгчөөр, мөн Японы Монгол судлалын нийгэмлэгийн тэргүүнээр олон жил ажилласан, нэрт эрдэмтэн Озава Шигэо, Азийн их сургуулийн профессор, монголч эрдэмтэн Койбүчи Шиничи гээд нэр цуутай монголч эрдэмтэд, мөн Чива их сургуулийн профессор, археологийн Като Шинпэй багш, Тоокай их сургуулийн хиймэл дагуулын мэдээллийн нэрт профессор Саката Тошифүми, Кавасаки Чишицү компанийн геофизикийн судалгааны мэргэжилтэн Тонюүчи Масахарү нар ажилласан. Тэднийг дагалдан ажиллаж байсан багийн гишүүд шавь нар нь эдүгээ олон бүтээл туурвилын эзэд эрдэмтэд болоод байгаа. Манай талаас түүх, археологи, угсаатны зүй, палеонтологи, геофизик, газар зүй, геологи, ургамал судлал гээд олон салбарын төлөөлөх томоохон эрдэмтэд судлаачид оролцож явсныг монголчууд их сайн мэддэг. Тэр үед ид 20 гаруй настай явсан залуус ажил мэргэжлээрээ өсч өндийн, нээлт бүтээлээ туурвиж, нэр алдраа дуурсган шинжлэх ухааны тавцанд байр сууриа баттай эзэлжээ.

Гурван голын монгол, япон хоёр талын аж ахуйнхан, жолооч, тогооч нар, газарч хөтөч нар маань ёстой хүний төлөө сэтгэлтэй энгийн сайхан хүмүүс байж, хөдөө хоггүй тарчиг хомс байсан тэр үед өвлийн хүйтэн, зуны халуун, цаг улирлын хатуу бэрхэд олон цөөн хоногоор отог дээр байж хээрийн судалгаа хийх хүмүүсийг ч, нааш цааш явах аян замын хүмүүсийг ч япон, монголгүй цөмийг нь тав тухтай, сэтгэл хангалуун, найрсаг нөхөрсөг байлгаж чадаж байсан юм даг. Тэр 90-ээд оны үед өнөөгийнх шиг хүссэн газраа саадгүй давхиад хүрэх засмал зам, дуртай үедээ хаашаа хэнтэйгээ ч ярьж болох гар утас, нийтийн хоол ундыг дор нь амжуулах газын плитка ямар байсан биш дээ, сураг ч байгаагүй. Харин Японоос авчирч, хамтарсан судалгаанд хэрэглэсэн Мицүбиши үйлдвэрийн Пажеро жийп хайгуулын ажилд ч, аян замд ч дотор нь суусан хэн боловч их л тохь тухтай явдаг, машины гоё ганганыг ч хэлэх үү, тэр үед манайд тийм машин цөөхнийг ч хэлэх үү, хаа ч явсан хүн амьтны

хараа татаж, зогссон газарт нь хэзээ л бол хүмүүс тойрчихсон үзэж сонирхож байдагсан. Хэдэн жилийн өмнө Гурван гол төслийн 20 жилийн ой тохиож, эрдэм шинжилгээний хурал, дурсамж уулзалт болж, зургийн үзэсгэлэн дэлгэгдэн экспедицийнхэн япон, монголгүй халуун бүлээрээ цуглаж, найз нөхдийн хөгжилтэй сонин яриа өрнүүлж байж билээ.

Гурван гол төслийн үед манай улсын тухай Японы олон нийтэд өргөнөөр танилцуулсан. Төсөл хэрэгжихээс өмнө 1980-аад оны сүүлчээс Зөвлөлтийн өөрчлөн байгуулалтын бодлого хэрхэн өрнөх, социалист системийн хандлага хааш эргэх нь вэ гэдгийг япончууд соргогоор ажиглаж, хэвлэл мэдээллээр нь энэ сэдэв идэвхитэй яригддаг байсан. Японд жил тутам хэвлэгддэг орчин цагийн үгсийн сангийн толь бичигт 1988 онд хамгийн идэвхтэй хэрэглэгдсэн үг хэллэгийн эхний байранд “перестройка” гэдэг үг шалгарч байж билээ. Яг энэ үеэс Японы өдөр тутмын дөрвөн том сонины нэг Ёмиүри сонинд Эмото Ёшинобү гэдэг хүний манай улсад хийсэн өнгөт фото зурагтай сурвалжлага байн байн бүтэн нүүрээр нийтлэгдэх болж, Монголын хангай, говь, Чулуут голоор аялсан нэрт зохиолч Кайко Такэши-гийн аяллын баримтаг кино телевизээр нь цацагдан манай орны байгалийн үзэсгэлэн, малчин ахуйн фон дээр Кайко зохиолчийг гарган Сантори вискийг рекламдаг байсан. Монголын талаар япончуудад улам сонирхолтой танилцуулах гол оньс нь агуу Чингис хаан мөн гэдгийг Эмото сурвалжлагч ч, Кайко зохиолч ч сайн мэдэж байсан. Тэгээд ч цаг үеийг олж ШУА-ийн удирдлагатай уулзан монгол эрдэмтдийн дэмжлэгийг авч Гурван гол экспедицийн хамтын судалгаа эхэлсэн байх. Экспедицийн Удирдах хороо, хээрийн судалгааны багт Ёмиүри сонины редакцийн гишүүд, сурвалжлагч нар, фото зурагчид ажиллаж, эрдэмтэд, судлаачдаас эхлээд орон нутгийн иргэд малчид, түүх домог мэдэх өвгөчүүл, улс төр, засаг захиргааныхан гээд төрөл бүрийн хүмүүстэй уулзаж явахад нь миний бие олонтаа хамт явж, шинэ сонин яриа хөөрөөг нь сонсож, газар үзэж, нүд тайлж билээ. Ингэж явахад дуулж мэдсэн, үзэж харсан маань одоо ч санаанд тодхон байдгаас заримыг нь энд дурдая гэж бодлоо.

1992 оны хаврын судалгааны үед хээрийн отог Өмнөдэлгэр сумаас зүүн хойш Хэнтийн нурууны салбар уулсын хажуу суганд зүүн, зүүн хойд талаар Хурхын өргөн хөндий цэлийн үргэлжлэх

сайхан нутаг Жаргалантын голын хөвөөнд буусан байхад манайхан Балдан Бэрээвэн хийдэд очиж билээ. Эмто гуай сонины хэд хэдэн хүний хамт 2 машин улс явсан. Хаврын урь орж, гол ус гэсч, шинэ ногоо ид гарч, яргуй цэцэглэсэн сайхан өдөр байсан. Гэхдээ л тэр үед ойн түймэр ихтэй, биднийг хийдэд очиход хойд талын аглаг дагшин Мөнх Өлзий хайрханд түймэртэй, уулын хяраар гал утаа нь үзэгдэж байж билээ. Ардчиллын дараа сүм хийд дөнгөж сэргэж эхэлсэн үе, Бэрээвэн хийд модон дуганаа барьчихсан, лам нар нь цуглаж эхэлж байсан үе. Хийдэд их сайхан яриа хөөрөөтэй настайвтар лам, хэдэн жижиг банди биднийг угтсан. Би болгоомжгүйгээс тэр үед тэмдэглэж авсан дэвтрээ хайгаад олоогүй, харин Өмнөдэлгэр сумын уугуул, тусч дүү Түмэндэлгэрээс лавлаж байж тэр ламын нэрийг Мөнхбаярын Товуу гэж мэдэж авсан. Өвгөн ламтан япон сурвалжлагчтай дотно сайхан яриа өрнүүлж, асуултад нь товч тодорхой хариулж, сүм хийд, орон нутаг, өөрийн түүх намтраа аргагүй л номын хүний буурь заан ойлгомжтой сайхан, орчуулахад хялбархнаар тайлбарлаж байсансан. Товуу ламын хуучилснаар Балдан Бэрээвэн хийд бол Монголдоо алдартай 5 том хийдийн нэгэнд багтдаг, олон мянган ламтай, Халхын Утай гүмбэн нэртэй, бурхан номын ариун дагшин орон байжээ. Өөрөө бага байхдаа энэ хийдэд шавилан сууж байсан, өнгөрсөн зууны 30-аад оны цөвүүн цагийн эхэнд багш ламаас эцэг эхэд нь хэл хүргүүлсний дагуу ээж нь ирж хүүгээ хийдээс авч буцсан, тэгэхдээ хийдийн зүүн талын гозгор уулын энгэрт хоёул мөргөн залбирч, ээж нь бурхан сахиусандаа учирлан хүүгийнхээ буян заяаг даатгаад, гэрийн зүг мордсоноо дурсан ярьсан. Хэлмэгдүүлэлтээс өмнө Чойбалсан хоёр ч удаа Бэрээвэн хийдэд ирсэн. Бэрээвэн хийдээс баруун тийш холгүй орших Элгэний рашаанд Чойбалсанг ирэхэд рашаан гараагүй, тиймээс манай хувилгаанд учрыг ярьж, тэнд очиж өгөхийг хүсч эхний удаа ирсэн. Чойбалсан машинаараа, түүнтэй зэрэгцэн манай хувилгаан шавиа дагуулаад морьтойгоо энэ баруун урд энгэрээр ергүүлээд давж байсан. Рашаан ч гарч, Чойбалсан тэнд амраад буцсан, түүнээс хойш дахин ирж, маршал хувилгаан хоёр найз нөхдийн хувиар уулзаж байсан хэмээн эгээ л кино үзэж байгаа юм шиг ярьсансан. Бас цаг үе эргэж их хэлмэгдүүлэлт эхлэн манай хийдээс гурав дөрвөн удаа лам нарыг ачаад явсан. Тэгээд ч хийд орон аяндаа бууран доройтож, эвдэрч үрэгдсэн, харин манай нутагт хамбыг маань Чойбалсан хороогоогүй,

өөр нэр өгөөд баруун аймаг руу гаргасан гэсэн яриа үлдсэн гэж ярьж билээ. Тэгээд “Манай хоёр хувилгааны зураг. Маршалыг ирэхэд авахуулсан зураг” хэмээн хоёр ламын зэрэгцэн зогссон зураг үзүүлж, сэргээн томруулж өгч туслахыг хүссэнийг Ёмиүригийнхэн хүлээн авсан санагдана. Товуу лам хийдээс яваад хожим Өмнөдэлгэрийн нэгдэлд мал маллаж, бүр Улсын сайн малчин болсон тухайгаа ч хуучилсан, хийд дээрх гэрт нь Улсын сайн малчны улаан халз уяастай байсан. Тийм нэгэн эрхэмтэй уулзаж ухаарал, уянга шингэсэн халуун сайхан яриаг нь дамжуулж байж билээ. Би орчуулгын ажил хийж гэрт байсан, харин манайхан хийдийн ойролцоох уулаар явсан, олон янзын бурхдын зураг, маанийн үсэг, соёмбо хаданд сийлээстэй байна, эхийн умай, тэндээс гараад хэвтэх хадан өлгий ч байна, цэцэг навч нь ургаад хачин сайхан байна гэхчлэн ярьж байсан. Бэрээвэн хийд аргагүй л том газар байсныг гэрчлэн чулуун балгас, газрын налууг гарган зассан хэдэн зуун гэр, байшингийн буйр уулын энгэрийг дүүргэн ив ил харагдаж байсан. Дуганы ойролцоох их том ургаа модыг “хүслийн мод, ээж мод” гэж хэлсэн. Энэ хэсэг бол зөвхөн лам хуврагуудын гэрийн буйр, энгийн айлууд нь тээр доогуур тусдаа байдаг, хийдийн газар руу эмс хүүхнүүдийг хамаагүй оруулдаггүй байсан гэсэн. Ийнхүү шашин номын газар дөнгөж сэргэж эхэлж байх тэр үед Балдан Бэрээвэн хийдэд очих завшаан тохиож байсансан. Тэр үед хийдэд нутгийнхнаас өгсөн адуу малтай, малаа тэндээ малладаг, арай томоохон шавь нар нь адуундаа явсан гээд 10-аад насны хоёр гурван банди хийд дээрээ байсан. Хүн цөөтэй, аглаг энэ нутагт хурал номын газар хөл дээрээ босч, хийд сэргэхэд хэцүү байх даа, лам нар олон байгаасай гэсэн сэтгэлээр гадаа барилдаж байсан тэднээс гэрээдээ буцчихгүй биз дээ гэх маягийн асуулт асуухад “Багштайгаа эндээ байна оо” гээд их л догь байж билээ. Тэд нар өдийд номтой том лам болцгоосон байгаа даа, хийд нь ч хөгжин тэлж, шашин соёл, аялал жуулчлалын, хөл ихтэй сайхан газар болж байгааг сонсч, сэтгэлд нэг л өег дотно байдаг юм. Эртний түүхт тэр аглаг дагшин нутагт, бурхны номын газрын өлмий улам батжин, монгол түмнийхээ зам мөр, сэтгэл үйлсийг ариусган тэгшилж байгаасай хэмээн чин сэтгэлээс хүсч явдаг юм.

Эмото гуай ихэвчлэн Чингис хаантай холбоотой гэгдэх газар ус, түүх домог мэдэх нутгийн хүмүүсийг зорьж очдог, сонины зурагчин голдуу хамт явдаг, тэнд хууч домгоос аваад хүн зоны өдөр тутмын аж

амьдрал, мал ахуйн талаар яриа хөөрөө өрнөж, Гурван гол төслийн явц болон тухайн үеийн манай улсын нийгэм, эдийн засаг, хөдөө нутгийн үйл амьдралын талаар тэдний хийсэн сурвалжлага, зураг хөрөг Японд Ёмиүри сонинд тогтмол нийтлэгддэг байсан. “Анх Монголд сурвалжлага хийхэд амаргүй байсан. Чингис хааны төрсөн нутаг Дадал орох хүсэлт гаргахад Хэнтий аймгийн удирдлага янз бүрийн шалтгаан хэлж цааргалдаг байсан. Нэг удаа Дадал явахын оронд Хятадтай холбоотой чухал юм үзэхийг санал болгож, 1971 оны 9 дүгээр сарын 13-ны шөнө хуучин Идэрмэг сумын нутагт сүйрсэн Хятадын БХЯ-ны сайд, маршал Линь Бяо-гийн онгоцны үлдэгдэл дээр дагуулж очсон. Ёмиүри сонинд зурагтай нийтлэл гаргасан нь өрнөдийнхний дунд шуугиан тарьсан” гэж ярьдагсан. Нутгийнхан Мөнгөн морьт, Батширээт, Баян Адрага, Биндэр, Дадал, Дэлгэрхаан гээд хаа ч явсан Гурван голынхныг сайн мэддэг, найрсгаар угтаж, дайлж цайлдаг байсан. Өвөл хаврын хатууд өрөм цөцгийтэй талх, тарган мах, борцтой хоол, жимс ногоо, нэрмэл архиар нь дайлуулж, япон монголгүй хоол ундных нь амттай сайхныг гайхдагсан. Нэгэн удаа япон эрдэмтдийн томоохон баг нисдэг тэргээр Дадал орж, Бадамхатан багш ойр хавийн түүх дурсгалт газруудыг танилцуулан тайлбарлаж, тэртээх XIII зуунд л бараг дагуулж очсон. Их эзний төрж өссөн, намтар түүхийн гэрч болсон газар нутгаар машинаар тойрч, Гурван нуурын амралтад үдэлсэн. Эрдэмтэн багшийн яриа багийнхны сэтгэлийг хөдөлгөснийг ч хэлэх үү, зуны сүүлч үеийн Онон голын бэлчир, Дадал нутгийн байгалийн хосгүй үзэсгэлэнг ч хэлэх үү, түүн дээр нутгийн иргэд хээрийн гал дээр хийсэн загасны шөл, буриад талх тэргүүтнээрээ дайлж, япончуудын дунд байдаг “социалист Монголын гундуу ойлголт”-ыг эргүүлэх шиг л болж байсан. Бадамхатан багш нисдэг тэргээр ч машинаар ч, явсан газар бүртээ, замын дагуу ойр тойрны уул усыг зааж, газар усны нэрээс эхлээд тэдийд тийм үйл явдал болсон, тийм учиртай газар гээд л, заримыг нь бүр дулаан цагт мориор явахад хэцүү, намаг шалбааг ихтэй ч гэж байх шиг, намрын цагт буугаад хэд алхахад л дээлийн хормой будчихдаг тийм их нэрстэй ч гэж байх шиг байнга л газар орноо таньж мэдэх талаас нь сануулж сургаж явдагсан, Дэлгэрхаанаас нааш Баян Эрхтий хайрхан, Баянжаргалан сум, Бөөрөлжүүтээр дамжаад ирж явахдаа бага насны дурсамжаа

хуучилж, наадам хийж байсан газар, морь уралддаг замыг зааж өгч явсансан.

Экспедицийн турш явсан газар, үзсэн дуулсан минь одоо бодоход ямарч их байж вэ дээ. Тэр үедээ анзаараагүй ч юм шиг. Алдарт Бурхан Халдун Хан Хэнтий уулын баруунхан талд Их Даваанд, мөн зүүн өмнө нь тун ойрхон Босгын давааны ард Богдын голд хээрийн отог бүтэн сараар бууж, уулын энгэрийн Хөх нуур, дунд, доод овоогоор хайгуулын багийнхантай явж, тэнд урь унах, цас ханзрах, хөхөө донгодохыг үзэж явлаа. Хөдөө арлаас аваад Хэрлэн Тооно уул, Их Хайлаант, Хар Зүрхний Хөх нуур, Өглөгчийн хэрэм, Тэмээт хайрхан, Биндэрийн уул Рашаан хад, Дуурлиг нарс, Дэлүүн Болдог, хилийн ойролцоох Хонгор уул, Хэрлэн, Онон, Туулын эх ундарга гээд монгол хүний сэтгэл зүрхний шүтээн болсон ариун дагшин уул хайрхад, рашаан уснаа хөл тавьж, нүдээрээ харж, түүх домог, утга учрыг нь чихээрээ сонсож, бас түүнийгээ чадан ядан орчуулж явсан минь эвлүүлж бичихэд чадал дутах нандин дурсамж үлдээжээ. Олон газраар буйр сэлгэдэг хээрийн отог байнга хөл ихтэй, тус тусын чиглэлээр хайгуулдаа явдаг, мэдээллээ цуглуулж боловсруулдаг, бүтээлээ туурвидаг, төлөвлөгөөгөө ч ярилцдаг, хурал цуглаанаа ч явуулдаг, санал дүгнэлтээ ч гаргадаг, шаардлагатай үед хиймэл дагуулаар дамжуулан Токио, Улаанбаатартай ч харилцдаг судалгаа шинжилгээний дутуу юмгүй хотхон байсан. Тухайн үеийн шинжлэх ухааны олон салбарын арга зүй, өндөр технологи ашиглан хэрэгжүүлсэн уг эрэл хайгуул Монгол, Японы төдийгүй дэлхийн судлаачид, олон нийтээс Монгол судлал, Чингис хаан судлалд хандах анхаарал сонирхлыг эрс сэргээсэн. Харин Их Эзний онгон өөрийн нууцаа хадгалан үлдэж, шинжлэх ухааны хөгжлийг дахин сорьж үзэх хугацаагаа хойшлуулаад байгаа. Бас Японы олон нийтэд хандсан манай улсын талаарх өргөн танилцуулга сурталчилгаа энэ экспедицтэй зэрэгцэн эхэлсэн монгол сумочдын идэвхи зүтгэлтэй хосолж, хоёр орны бүх талын харилцаа, хамтын ажиллагаа огцом хурдтай өргөжин хөгжихөд хувь нэмрээ оруулсан. Эцэст хэлэхэд энэ экспедиц Чингис хааны судлалд үнэтэй хувь нэмэр оруулсныг нийтээр хүлээн зөвшөөрсөн.